



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ**

2022 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 698

Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө акталж, данснаас хасах
зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6.4.5, 6.4.6 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1.ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, ашиглалтын хугацаа дууссан, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, 15 нэрийн, нийт 21,435,405.66 (хорин нэгэн сая дөрвөн зуун гучин таван мянга дөрвөн зуун таван төгрөг жаран зургаан мөнгө) төгрөгийн балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасахыг зөвшөөрсүгэй.

2.Соёлын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Оюунбилэг, ЮНЕСКО-ийн ивээл дор Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн захирал И.Бямбабаатар нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1.Байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан хөрөнгийг акталж, данснаас хасах, устгах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2.Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, арга хэмжээний биелэлтийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3.Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
АШИГЛАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Д.НАРАНГЭРЭЛ

1370000000

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн
698. дугаар тогтоолын хавсралт

**ЮНЕСКО-ИЙН ИВЭЭЛ ДОР НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ СУДЛАХ ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭНГИЙН
ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, АКТАЛЖ ДАНСНААС ХАСАХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Хөрөнгийн нэр, марк	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Ашиглалтад орсон он	Нэг бүрийн үнэ (төгрөг)	Балансын үнэ, хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Үзмэрийн шүүгээ	Ш	2	1/1/2009	4,440,465.92	8,880,931.84	0
2	Акумлятор	Ш	1	1/2/2009	50,313.80	50,313.80	0
3	MNB-6050	Ш	1	1/1/2003	305,625.00	305,625.00	0
4	Сандал /ногоон/	Ш	5	1/1/1999	1,100.00	5,500.00	0
5	Сандал /ногоон/	Ш	10	1/1/2002	32,583.70	325,837.00	0
6	Шил хоорондын хаалт	Ш	8	1/1/2008	109,900.00	879,200.00	0
7	Хоёр хүний ширээ/9008/	Ш	1	1/1/2004	969,850.00	969,850.00	0
8	Шилэн хорго	Ш	2	1/1/2009	527,788.40	1,055,576.80	0
9	Шилэн шүүгээ	Ш	1	1/1/2009	4,178,672.22	4,178,672.22	0
10	Урт залгуур	Ш	4	1/1/1999	10,524.75	42,099.00	0
11	Номын тавиур	Ш	2	1/1/2004	1,237,170.00	2,474,340.00	0
12	Флаш диск/256 мГВТ/	Ш	1	1/1/2005	52,650.00	52,650.00	0
13	Флаш диск/256 мГВТ/	Ш	1	1/1/2005	52,650.00	52,650.00	0
14	Канон /3/	Ш	1	1/1/2008	1,711,710.00	1,711,710.00	0
15	Камер /sony /	Ш	1	1/1/2008	450,450.00	450,450.00	0
	НИЙТ ДҮН		38		11,969,293.79 (арван нэгэн сая есөн зуун жаран есөн мянга хоёр зуун ерэн гурван төгрөг далан есөн мөнгө)	21,435,405.66 (хорин нэгэн сая дөрвөн зуун гучин таван мянга дөрвөн зуун таван төгрөг жаран зургаан мөнгө)	